



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 68

Эрдэнэт

2018 онд ойгоос түлшний мод бэлтгэх  
дээд хэмжээ батлах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь заалт, 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2017 оны А/235 дугаар тушаалыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Ойн сангийн төлөв байдал, ойн нөөцийг харгалзан 2018 онд Жаргалант сумын ойн сангаас ойн цэвэрлэгээгээр бэлтгэх хэрэглээний шинэс модны дээд хэмжээг 150 шоометр, түлээний шинэс модны дээд хэмжээг 1500 шоометрээр тус тус тогтоосугай.

2. Холбогдох хууль, журмын дагуу ойгоос бэлтгэх модны төрөл, тоо хэмжээг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр тогтоохыг Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвшөөрсүгэй.

3. Орхон аймгийн иргэдийн түлээний модны хэрэгцээг Ойн цэвэрлэгээ хөтөлбөр хэрэгжиж байгаа аймагтай харилцан тохиролцож, түлээний модоор хангах асуудлыг шийдвэрлэхийг Жаргалант сумын Засаг дарга /Д.Зоригтбаяр/-д, Баян-Өндөр сумын Засаг дарга /С.Ганцогт/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга/Д.Батлут/-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА

C:\Togtool \-A4 doc

0010270